



ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал,  
эрүүл ахуйг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулах, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо–Шаардлага, хэрэглэх заавар” MNS ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэн тогтвортой үйл ажиллагааг хангах, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт ДААЛГАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасны дагуу (Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна) холбогдох зардлыг энэ хуулийн 26.5-д заасан арга хэмжээнд зарцуулах;

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4, 28.1.5 дахь заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-д заасны дагуу байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм” болон холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрмийн талаарх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтарч алба хаагчдад зохион байгуулж, сургалтаар бататгасан мэдлэгээр шалгалт авч, баталгаажуулж, хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд дахин судлуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бүсийн төвийн Хөдөлмөр хамгаалал, техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн нарыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багшийн сургалтад суралцах зардлыг шийдвэрлэн суралцуулж, багшлах эрхийн гэрчилгээ олгуулах;

5. Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” шинэчлэн батлагдсантай холбогдуулан нийт бүрэлдэхүүнд (офицер, ахлагч, албан тасалгааны ажилтан, нийт үйлчилгээний ажилтан) дүрмийн сургалтыг зохион байгуулж, ажил үүргийн чиглэл тус бүрээр зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулан батаалгаажуулж хэвших;

142410001

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дэх хэсэгт заасны дагуу нийт алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1-ээс доошгүй удаа хамруулах ажлыг чанартай зохион байгуулах;

7. Нийт алба хаагчдыг хачигт халдвар, тарваган тахал, томуу, томуу төст өвчин, элэгний В, С зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад товлोलт хугацаанд хамруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

8. Алба хаагчдын үйлдвэрлэлийн осолд өртсөн мэдээллийг тухай бүрд нь, гэнэтийн ослын даатгалын байгууллагын үйлдвэрлэлийн ослын бүртгэлийн мэдээг улирал бүр нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж хяналт дүн шинжилгээ үнэлгээ хийн, үүрэг чиглэл өгч ажиллах;

9. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/99 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журмын дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэс, анги, салбар нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, улирлын тайлан мэдээг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэх.

10. Албан даалгаврын хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг заалт тус бүрээр гарган хавсралт 1-д заасан мэдээний хамт хагас жилийн тайланг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдөр, жилийн тайланг 11 дүгээр сарын 11-ний өдрийн дотор Гал түймэртэй тэмцэх газарт ирүүлэх.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН